



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 530

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 321,671,826.00 (гурван зуун хорин нэгэн сая зургаан зуун далан нэгэн мянга найман зуун хорин зургаан) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа О.Амарсанаа болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны дүгээр сарын 1-ны өдрийн
150 дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬАА БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ
АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| Д/д | Байгууллагын нэр | Автомашины нэр, марк, улсын дугаар, арал, хөдөлгүүрийн дугаар | Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он | Балансын нийт үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | ТӨБЗГ-ын 2021 оны 564 дүгээр тогтоолоор худалдах доод үнэ | ТӨБЗГ-ын 2022 оны 240 дүгээр тогтоолоор худалдах доод үнэ (50% буурсан үнэ) | Сэлбэгээр худалдсанаас олох орлогын доод хэмжээ үнэ (төгрөг) |
|-----|--|---|-----------------------------------|---|---|---|--|
| 1 | Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь ШШГХ-423 дугаар нээлттэй, хаалттай хорих анги | Чиргүүл (ЗИЛ 130 машины) | 1982/1982 | 1,500,000.00 | 100,000.00 | 50,000.00 | 25,000.00 |
| 2 | 405 дугаар хаалттай хорих анги | Фургон, 68-97 УНЦ (арал-А0420621, хөдөлгүүр-А0002247) | 2010/2010 | 18,100,000.00 | 1,000,000.00 | 500,000.00 | 150,000.00 |
| 3 | Цагдан хорих 461 дүгээр хаалттай анги | ПАУ автобус 64-61 УНВ (хөдөлгүүр-WA162061, арал- LGF199HG9DF108501) | 2013/2013 | 58,000,000.00 | 800,000.00 | 400,000.00 | 150,000.00 |
| 4 | | Паз 3205, 59-48 БУЛ (арал- 40008859, хөдөлгүүр 523400) | 2004/2004 | 28,000,000.00 | 800,000.00 | 400,000.00 | 150,000.00 |
| 5 | | Kia Rhino, 05-88 БУЛ (арал- KN3SAP842YK0038558) | 2000/2000 | 24,000,000.00 | 800,000.00 | 400,000.00 | 150,000.00 |
| 6 | 439 дүгээр хаалттай хорих анги | Бохирын машин 02-77 ОРО (арал-LGDCH81G7CA143512) | 2012/2012 | 27,567,826.00 | 800,000.00 | 400,000.00 | 150,000.00 |
| 7 | | Фургон, 34-90 БУЛ (арал-374100E0446335, хөдөлгүүр- 409110E3036358) | 2014/2014 | 31,000,000.00 | 1,000,000.00 | 500,000.00 | 150,000.00 |
| 8 | 409 дүгээр хаалттай хорих анги | Хьюндай аэро таун, 05-30 УБЕ (арал-KMJNN19AP1C3061) | 2001/2012 | 35,000,000.00 | 800,000.00 | 400,000.00 | 150,000.00 |

